



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 5/52

Ховд

Ч.Нэргүйг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Буянт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 1/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05/14557 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Чойдогийн Нэргүйг 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн Буянт сумын Засаг даргаар томилсугай.

2. Ч.Нэргүйд Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 979762 төгрөг /Есөн зуун далан есөн мянга долоон зуун жаран хоёр/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Буянт сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Д.Болортуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Ч.Нэргүйд даалгасугай.

4. Ч.Нэргүйгийн ажлыг хүлээлцүүлэхийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Ш.Даваатогтох/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/52 Ch
02 4295